

## **ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 03 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

### **Нэг. Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:**

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж, 8 асуудал хэлэлцэж, 1 асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр, 2 асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлахаар тус тус шийдвэрлэв.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 23 өргөдөл бичгээр хүлээн авснаас, 16 өргөдлийг шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Засаг даргын Тамгын газар 4 өргөдөл бичгээр хүлээн авснаас 3 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 6 өргөдөл хүлээн авч шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 1 сувгаар дуудлагаар 15 иргэн санал, гомдол ирүүлсэнээс гомдол 8, санал хүсэлт 7 буюу Орчны эрүүл ахуйн чиглэлээр 2, хууль эрх зүй 1, эрүүл мэнд 2, бусад 10 санал хүсэлт бүртгэж, холбогдох хэлтэс, тасгийн дарга нарт шилжүүлж, бүх санал хүсэлт, гомдолд хариу өгч, шийдвэрлэлт 100 хувьтай байна. Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд 3 санал хүсэлт, 3 гомдол хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлэн хариу илгээлээ.

Аймгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг сар бүрийн 1, 3 дахь долоо хоногийн Мягмар гарагийн 10 цагт тогтмол хийж, аймаг, орон нутгийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, цаг үеийн мэдээлэл түгээх ажлуудыг шуурхай зохион байгуулж шийдвэр гарснаас хойш 9 дэх удаагийн зөвлөгөөнийг зохион байгуулж хэвшээд байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт байгууллагын өдөр тутмын ажил хэргийг автоматжуулан нэгдсэн зохион байгуулалтад оруулах, ажлыг хурдан шуурхай явуулах Эйбл системийг нэвтрүүлсний дээр орон нутгийн 3 телевиз /Эко, Ховд, Жаргалант/, 1 сонин /Ховдын мэдээ/, Ховд нь юс сайттай гэрээ байгуулж гэрээний дагуу телевизүүд болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаж байна. Аймгийн албан ёсны вэб сайт болох [www.khovd.gov.mn](http://www.khovd.gov.mn) цахим сайтад цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол тавьж, өдөр тутам шинэчлэн цаашид илүү хүртээмжтэй болгоход анхааран ажиллаж байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 3 дугаар сард улсын төсвөөс авах санхүүжилт хугацаандаа бүрэн ирж, сум, байгууллагуудад санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хянан санхүүжүүлж байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланг хүлээн авах, аудит хийлгэх, нэгтгэх талаар СТСХ-ийн даргын 64 тоот албан бичгээр

зөвлөмж хүргүүлэн аудитлагдсан тайланг цахим “Э” тайлантай тулган баталгаажуулж, баталгаажуулалт 94.1 хувьтай байна. Аймгийн ААН, байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 1522 аж ахуйн нэгжээс авахаас 1393 нэгжийн тайлан авч нэгтгэж, 91.5 хувийн хамрагдалтай, хугацаандаа ирүүлсэн 1229, хугацаа хоцорсон 164, тайлан ирүүлээгүй 129, баталгаажуулаагүй тайлан 1 байна. Тайлан авалт өнгөрсөн оныхоос 3 хувиар өссөн байна. ААНБ-ын 2016 оны жилийн эцсийн нэгдсэн тайлангийн дүн, мэдээний илтгэх хуудас бичиж аймгийн ЗДТГ-ын албан бичгээр хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэв.

Төсвийн байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн тайлангаас төсвийн гүйцэтгэлийн зарим гол тоо, мэдээлэл авч боловсруулалт хийж, төсвийн зөрчилтэй байгаа сум, байгууллагуудын Санхүү албаны дарга, нягтлан бодогч нарт заавар зөвлөмж өгч, ажлыг дүгнэж байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Татварын хэлтсийн 2016 оны орлого бүрдүүлэлт, хураалт, татварт хамрагдалтын талаар тайланг сонсон, хэлэлцүүлэг хийж, орлогын нөөц боломжийг судлан, татварт хамрагдахгүй байгаа орлогыг илрүүлэх, эрсдэлтэй, орлого өндөртэй ААНБ-д хяналт шалгалт хийх, татвар хураалтыг сайжруулах, бусад төрийн байгууллагатай хамтран ажиллах замаар сар бүр орлогын төлөвлөгөөг биелүүлэх үүрэг чиглэл өглөө.

Мөн аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2016 оны төсвийн байгууллагуудад хийсэн хяналт шалгалт, гарсан зөрчил дутагдлын талаар сонсгол мэдээлэл сонсож, цаашид төлбөр гаргахгүй байх, зөрчлийг хэрхэн яаж арилгах талаар санал, бодлоо солилцов. Санхүүгийн хяналт шалгалтаар 2016 онд аймгийн төвийн 39 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, нийт 206.0 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, 151.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 54.4 сая төгрөгийг тухайн байгууллагад оруулахаар акт тавьж, төсвийн орлогод 80.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Гарсан зөрчлийн дийлэнх хувийг үндсэн баримтгүй зарцуулсан, данс бүртгэлд тусгаагүй, өр авлага үндэслэлгүй хаасан, дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхөн олговор, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, албан татвар төлбөр хураамж дутуу ногдуулсан зэрэг дутагдал эзэлж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн 2016 оны тайлан гаргаж Сангийн яам, аймгийн Засаг даргад ирүүлсэн байна. Эндээс үзэхэд төсвийн Ерөнхийлөн захирагчийн 134 төсөвт байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилт 84.3, Орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагууд 63,5 хувьтай байна.

Татварын хэлтэст нь 2016 оны НӨАТ тайланг 362 нэгж ирүүлсэн нь 96.8, ААНОАТ 1619 аж ахуйн нэгж ирүүлсэн нь 94,6 хувьтай байна. Улс, аймаг, сум орон нутгийн төсөвт 3 дугаар сарын байдлаар нийт 2559.0 сая төгрөг оруулахаас 1360.1 сая төгрөг оруулсан нь 53.1 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 155.5 сая төгрөг оруулсан нь 32.0 хувьтай, аймгийн төсөвт 1094.1 сая төгрөг оруулсан нь 58.7 хувьтай, сумын төсөвт 110.3 сая төгрөг оруулсан нь 53.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДНБ-ний тооцоо хийгдэх түүвэрлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн мэдээг ААНБ-1 маягтаар 265, ААНБ-2 маягтаар 567 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангаас гаргуулан авч, мэдээг онлайнаар програмын дагуу шивж Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь дамжууллаа.

Эхний 2 сарын аймгийн нийгэм, эдийн засгийн товч танилцуулгыг гаргаж аймгийн удирдлагуудад хүргүүлэв. ӨНЭЗС-г Жаргалант сумын Магсаржав, Буянт сумын Цагаан-Эрэг, Цэцэг сумын Хажинга багийн 3 нэгжийн 26 өрх, АХС-г Жаргалант сумын Буянт, Булган сумын Далт, Мянгад сумын Цагаанбулан багийн 3 нэгжийн 36 өрхөөр судалгаа хийгдэж байна.

**Гурав. Хууль эрх зүйн салбарын хүрээнд:** Сумдын Засаг даргын захирамж, тушаал хянах хуваарийн дагуу Үенч, Дарви сумдын захирамж, тушаалыг хууль тогтоомжийн хэрэглээ, үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр, хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргасан эсэх талаар хянан дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэхээр бэлтгэв. Архивын тасгаас 51 хүнд захирамж, тушаалын лавлагааг олгосон бөгөөд 3 хөмрөгийн 44 ширхэг хадгаламжийн нэгжийн 4270 хуудас материалыг цахим программд шивж оруулав.

**Цагдаагийн газар:** Аймгийн хэмжээнд 3 дугаар сарын 26-ны байдлаар 28 гэмт хэрэг гарч бусдын бие махбодид гэмтэл учруулах 6, хулгайлах 15, үүнээс иргэдийн өмчийн хулгай 10, малын хулгай 5, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 5, танхайрсан 1, хүчиндэх 1 гэмт хэргүүд тус тус бүртгэгдсэн. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 370 гомдол мэдээлэл хүлээн авсаны 75 буюу 20.0 хувийг гэмт хэргийн, 295 буюу 80.0 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 8 гомдол, мэдээлэл байв.

Зөрчил гаргасан 128 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, жижгээр танхайрсан зөрчилд 22 хүнийг 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлуулж, 60 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, зөрчил гаргасан 1245 хүнийг 53.654.100 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

“Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” илтгэлийн уралдааныг Жаргалант сумын 2 сургуулийн 115 сурагчдын дунд зохион байгуулав. 242 аж ахуйн нэгж, байгууллагад харуул хамгаалалтаа сайжруулах чиглэлээр албан мэдэгдэл хүргүүлж, 4 төрлийн санамж сэрэмжлүүлгийг иргэдэд тараав. Мөн архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг 235 аж ахуйн нэгжид үзлэг, шалгалт хийж холбогдох хууль тогтоомжоор сургалт зохион байгуулж мэдээлэл өглөө. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, хорихоос хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан, захиргааны хяналтанд байгаа 53 этгээдийн хаягийг тодотгон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулгыг хийв.

**Шүүхийн шинжилгээний алба:** Шүүхийн шинжилгээний албанд хандаж 22 албан бичиг, 68 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэн, байгууллагаас 17 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 8 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 71 хүнд, химийн 9, биологийн 9, криминалистикийн 7 шинжилгээ тус тус хийж, нийт 104 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд криминалистикийн шинжээч, шинжээч эмч, туслах ажилтан нар 5 удаа явж ажиллав.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 70 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын мөр 25, гутлын мөр 36, тээврийн хэрэгслийн мөр 23, бусад ул мөр, эд мөрийн баримт 24-ийг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 13, гарын мөр 6-г тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийлээ.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох, бүтцийн, химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүрт нь цахимжуулав.

Албаны үйл ажиллагаа, албан хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй байна. 2017 онд улсын төсвөөс нийт 187.519.000 төгрөгийн төсөв батлагдсанаас 3 сарын байдлаар цалин хөлс, нэмэгдэл урамшил, нийгмийн даатгал, ХАОАТ, хангамж бараа материалын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд нийт 39.647.683 төгрөгийг тус тус зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан бөгөөд төлбөрт үйлчилгээний орлогод 490.000 төгрөг төвлөрүүлээд байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба:** Тус алба нь 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар хүний нөөц сургалт, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 1, шийдвэр гүйцэтгэгч 2, хянагч 2, нийт 5 албан хаагч томилогдоогүй 59 алба хаагчтай ажиллаж байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавин ажиллаж 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг хичээл, сургалт жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулагддаг олон төрлийн тэмцээнд байгууллага хамт олноороо амжилттай оролцож 2 дугаар байр эзэлсэн.

Хорих ангийн харуул хамгаалалтыг "Хорих ангийн харуул хамгаалалт болон ялтанд хяналт тавих журам"-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албаны даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн, алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавьж ажиллав.

Ангийн байрлалаас 800м-т байрлах малын хэсэгт хянагчийн хяналтанд нэр бүхий 2 ялтныг ажиллуулж, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу шалган нэмэлт үүрэг даалгавар өгч байнгын хяналт тавьж байна. Албаны үйл ажиллагаа хууль журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд ялтан, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Энэ сард нийт 2288 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1742, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 456 ба шилжин ирсэн иргэд 52, шилжин явсан иргэд 52 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 352, гадаад паспорт олголт болон сунгалт 366, иргэний үнэмлэх шинээр олгосон 54, сунгалт 19, дахин олгосон 25, иргэний бүртгэлийн лавлагаа 455 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 367 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 457, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 78 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав. Иргэдээс нийт 11 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 3 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 4

өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлж, 4 өргөдлийн хугацаа шийдвэрлэх шатандаа байна.

### **Дөрөв.Нийгмийн бодлогын салбарын хүрээнд:**

**Боловсрол чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газар, БСШУСЯ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулж буй сургалтанд 1 болон 5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нар хамрагдаж, аймгаас нийт 5 мэргэжлээр 15 багш оролцов. Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын 5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын Баруун бүсийн сургалт 13-18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, нийт 94 багш оролцлоо. Уг сургалтаар II цэцэрлэгийн багш н.Өлзийбаяр биеийн тамир, Жаргалант сумын Y цэцэрлэгийн багш н.Сувдаа хөгжмийн үзүүлэх хичээлээр тус тус амжилттай оролцов. Мөн бага боловсрол хариуцсан мэргэжилтэн болон зөвлөх багш нар өөрсдийн ажил, мэргэжлийн туршлагаа түгээн дэлгэрүүлэн, лаборатори 1 дүгээр сургуулийн үйл ажиллагаатай танилцан туршлага солилцлоо.

Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яамны газрын дарга С.Болормаа, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын мэргэжилтэн н.Нарантуяа нарын хамтын оролцоотойгоор хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нээлттэй хичээлийг Жаргалант сумын YI, YII, YIII цэцэрлэгүүдэд, сургуулийн өмнөх боловсролын “Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам”, Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа. Монгол Улсын Засгийн газрын “Англи хэлний үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Олон улсын мэдээний клуб”, “Англи-Монгол ярианы клуб”, “Англиар кино үзэж ярилцах цаг” хичээлүүдийг үргэлжлүүлж, их дээд сургуульд элсэгчдэд зориулсан орос хэлний сургалтыг эхлүүлээд байна.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрөөс бага боловсролын хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжиж, бага ангийн сурагчдын эх хэл, математик, байгалийн ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх, сургалтыг дэмжих бүтээлч үйл ажиллагааны агуулгыг баяжуулах, хүүхэд бүрийн авьяас, давуу талыг нээх зорилгоор сургуулиудын санал болгосон төслийг санхүүжүүлэхэд 1 сургуульд 3000 ам.долларын тэтгэлэг /1,2 дугаар шатанд 13-11 сургуулийн төсөл шалгарч 144 сая төгрөг/ олгосон. Тус хөтөлбөрийн 3 дугаар шатны сургалтыг зохион байгуулж сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер нийт 48 хүн оролцож, 4 дүгээр сарын 1-нд төслөө бичиж өгөхөөр болов.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Чадварлаг багш” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд “Физикийн багаж тоног төхөөрөмжийн ашиглалт ба хэрэглээ” сургалтыг Монгол улсын их сургуулийн багш Б.Бат-Отгон, Ховд Их сургуулийн физикийн багш нар хамтран зохион байгууллаа. Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээний чанар стандартыг сайжруулах сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Норвегийн тусламжийн байгууллагатай хамтран “Хүүхдэд ээлтэй сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ” сургалтыг зохион байгуулж 25 сургуулийн 27 нийгмийн ажилтан оролцлоо. Мөн дотуур байрны хүүхдүүдийг эрүүл аюулгүй, чанартай хоол хүнсээр хангахад хамтын ажиллагааг сайжруулах, мэргэжил

арга зүйг эзэмшүүлэх сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран “Дотуур байрны хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг хангах арга зам” сургалтыг Зэрэг суманд амжилттай зохион байгууллаа.

Дэлхийн банк, “Глобаль удирдагч сан”-гаас хэрэгжүүлж байгаа “Боловсролын салбар дахь ил тод байдал эгэх хариуцлага” төслийн сургалтанд сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, нягтлан бодогч, БСУГ-ын мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөллүүдийг хамрууллаа. Боловсрол соёл урлагийн газрын даргын 2017 оны А/18 тоот тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын мэргэжлийн хичээлийн олимпиад зохион байгуулах журмын дагуу аймгийн ЕБС-ийн багш, сурагчдын мэдлэг, оюуны сорил болсон мэргэжлийн хичээлийн олимпиадын хоёрын давааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн шүүхийн 90 жилийн ойг тохиолдуулан тус байгууллагатай Боловсрол, соёл, урлагийн газар хамтран ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Шүүхийн байгууллагын тухай миний бодол” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулав.

Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл, олон нийтийн оролцоот сургууль төслийн хүрээнд 10 сумын сургуульд хяналт үнэлгээ хийх явцад төслийн багаас орон нутгийн бодлогын зөвлөл, хэрэгжилтийн багийн гишүүдтэй уулзалт хийж, төслийн үр дүнг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичгийг гаргав. Багшлах эрхийн шалгалтыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар хамтран зохион байгуулж шалгалтанд 105 шалгуулагч бүртгүүлснээс 101 шалгуулагч шалгалтанд орж 1 дүгээр шатны шалгаруулалтанд 84 шалгуулагч тэнцэв. Цэцэрлэгүүдэд цөм хөтөлбөрийн зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр зохион байгуулсан ажил, тулгамдаж буй асуудлын талаар илтгэл бэлтгэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүллээ. Боловсрол, соёл урлагийн газрын дэргэдэх сургалтын танхим, номын санг тохижуулан үйл ажиллагааг эхлүүлж, элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл хуваарийн дагуу хийгдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болон боловсролын тусгай хэрэгцээт 297 хүүхдийн судалгааг гарган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын мэргэжил дээшлүүлэх чиглэлээр холбогдох газар саналыг уламжлав. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа 60 хүүхдийн нэрс, дэлгэрэнгүй мэдээлэл, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа эсэхийн давхцалыг хянан үзэж, давхацсан 17 хүүхдийн мэдээллийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт албан бичгээр хүргүүлж, нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, зайлшгүй тулгамдсан барилгын их засвар зэрэг хөрөнгө оруулалтын судалгааг гарган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Санхүү эдийн засгийн газарт уламжлав.

**Соёл, спортын чиглэлээр:** Биеийн тамир спортын газрын 2017 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө болон сургалт бэлтгэлийн хуваарийн дагуу үндэсний бөх, жүдо бөх, чөлөөт бөх, самбо бөх, бокс, таеквондо, волейбол, сагсан бөмбөг, хөнгөн атлетик зэрэг спортын төрлүүдээр тамирчин, хүүхдүүд бэлтгэл сургуулилтанд хамрагдаж байна. Бэлтгэл сургуулилт 7 хоногийн ажлын өдрүүдийн өглөө, өдөр 2

ээлжээр хичээллэж байгаа бөгөөд бус, улсын чанартай тэмцээнүүдэд оролцох түвшинд бэлтгэгдээд байна.

Аймгийн Биеийн тамир спортын газрын түүхт 70 жилийн ойн арга хэмжээ энэ онд тохиож байгаа бөгөөд уг арга хэмжээний хүрээнд дараах тэмцээн уралдааныг зохион байгууллаа. Үүнд: Самбо бөхийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн 03 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохиогдож, аймгийн баг тамирчид 70 кг жинд Ш.Буянзаяа хүрэл, 75 кг жинд Н.Ойнбаяр хүрэл, 44 кг жинд Б.Туул хүрэл, 63 кг жинд О.Саруул мөнгөн медаль тус тус хүртсэн. Нийт 48 баг оролцсоноос аймгийн эмэгтэй баг тамирчид 3 дугаар байр эзэлж хүрэл медаль, цом, өргөмжлөлийн эзэн болов.

Аймгийн таеквондогийн аварга шалгаруулах тэмцээн 03 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдав. Тэмцээнд Увс аймгийн баг тамирчид ирж оролцон аймгийн аварга шалгаруулах тэмцээний шилдэг эрэгтэй тамирчнаар Б.Амархүү, шилдэг эмэгтэй тамирчнаар Б.Мишээлт, шилдэг багийн ахлагчаар Д.Наранчимэг нар шалгарсан бол таеквондогийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгийн баг тамирчид багаараа 2 дугаар байр эзэлсэн байна.

Мөн 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Жүдо бөхийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд аймгийн баг тамирчид амжилттай оролцож 63 кг жинд О.Саруул алт, 44кг жинд Б.Туул хүрэл медаль хүртэж О.Саруул шилдгийн шилдэг тамирчнаар шалгарлаа. Насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдаан аймгийн БТСГ-ын спорт цогцолборт амжилттай болж, Эрдэнэбүрэн сумын харъяат, аймгийн начин Цогтбазарын Заяатүшиг түрүүлж, Чандмань сумын харъяат, аймгийн харцага Энхболдын Эрдэнэбаяр үзүүрлэж, уран барилдааны шагналыг Д.Цэнд-Аюуш хүртлээ.

Хүүхдийн спортын бага наадмыг спортын 6 төрлөөр зохион байгуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** “Иргэдэд эрүүл мэндийн зөв дадал олгох арга зүй” сэдэвт БОЭТ, сум өрхийн эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулав. Ингэснээр нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд орон нутгийнхаа иргэдийн зан үйлд тулгуурлан сургалтын хэрэгцээ, зорилтот бүлгээ тодорхойлж сургалтын удирдамж төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр боловсрол олгох өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тасралтгүй үргэлжлүүлэн хийх юм.

2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж тус ажлын хүрээнд удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, 2016 оны сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажлыг дүгнэж, тэргүүний байгууллага, ажилтан нарыг урамшуулж, зорилго, зорилтоо дэвшүүлэн цаашид анхаарах асуудлыг хэлэлцлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс санаачлан төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутгийн бодлого төлөвлөлтөнд тусгах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс “Хэнийг ч орхигдуулахгүй байх” талаар дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэвшүүлсэн зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтыг төр, хувийн хэвшлийн байгууллагын удирдах болон бусад хамтрагч байгууллагуудын ажилтнуудыг оролцуулан зохион байгууллаа. Мөн “Усны аюулгүй байдал”, “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Бүсийн оношилгоо

эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт сүрьеэ өвчний тандалт судалгааны мэдээлэл сургалт зохион байгуулав.

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу “Осол гэмтлээс сэргийлэх”, “Хүүхдийн түлэгдэлт-Эцэг эхийн хариуцлагаас” сарын аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэнд, дархлаажуулалтын хамралтын болон зарцуулалтын тайланг Халдварт өвчин судлалын үндэсний төвд тус тус хүргүүлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс томуу, томуу төст өвчний мэдээг 7 хоног бүр авч нэгтгэн, сорьц тээвэрлэлтийн улирлын мэдээг холбогдох газруудад хүргүүлж, 2 дугаар улирлын товллын вакцин болон дагалдах хэрэгслэлийн татан авалтыг хийж дуусгав.

“Дэлхийн эрүүл мэндийн өдөр”-ийг тохиолдуулан “Эмч судлаач-2017” онол практикийн бага хурлыг удирдамжийн дагуу зохион байгуулж, нийт 26 илтгэлийг хэлэлцүүлэн шалгарууллаа. Тайваний Засгийн газрын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны санхүүжилтээр 758 сая төгрөгийн өртөг бүхий Гемодиализийн эмчилгээний аппаратыг аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд суурилуулав. Энэ нь бөөр шүүх эмчилгээнд хамрагдах үйлчлүүлэгчдийн хүлээгдэл чирэгдлийг бууруулсан үр дүнтэй арга хэмжээ болов.

Жаргалант сумын 8, 9, 13 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг, эхчүүдэд “Эмийн зохистой хэрэглээ”, “Антибиотикийн хариуцлагатай хэрэглээ” сэдвээр, “Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах нь”, “Эх хүүхдийн хоол тэжээл”, “Эх хүүхдийн дэвтэр хөтлөх” зэрэг сэдвээр сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан сургалтуудыг санаачлан зохион байгуулж тус сургалтанд 200 гаруй хүн хамрагдав.

**Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Хүүхэд хамгааллын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээ, эцэг эх, асран хамгаалагч нь асарч өсгөх боломжгүй 0-2 насны хүүхдийн судалгааг сумдаас авч нэгтгэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ.

03 сарын байдлаар аймагт 6, суманд 7 удаагийн морины уралдаан зохион байгуулагдаж 1111 морийг 428 хүүхэд унаж уралдсан бөгөөд уралдаанд оролцсон хүүхдээс 9 хүүхэд мориноос унасан мэдээтэй байна. Жаргалант, Эрдэнэбүрэн, Чандмань сумдад зохион байгуулагдсан хурдан морины уралдаануудад Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг дахь Хүний эрхийн Үндэсний комисс хамтран уралдааны зохион байгуулалт, уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн өмсүүлэх тал дээр хяналт тавьж ажиллав.

Хаврын хурдан морины уралдаан үсэргээ, сунгааг зохион байгуулахыг хориглосон Засаг даргын захирамж гаргаснаас ж хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сумдад албан даалгавар хүргүүлж, мөн аймгийн Алтайн унага морин спорт уяачдын холбоонд унаач хүүхдүүдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалж, урьдчилан сэргийлэх зорилгоор 5 дугаар сарын 1 хүртэл морины уралдаан зохион байгуулахгүй байхыг мэдэгдсэн албан бичиг хүргүүлэв.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2013 оны А/106 дугаар захирамжийн дагуу 03 дугаар сарын 23-ны өдөр гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажилласан дадлага сургуульд Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги оролцов.

“Хүүхдэд ээлтэй сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ” сургалтыг 2017 оны 03 сарын 10,11-ний өдрүүдэд Боловсрол соёл урлагийн газартай хамтран зохион байгуулж цахим орчин дахь хүүхэд хамгаалал, сургууль, цэцэрлэгт цахим орчны зохистой хэрэглээг бий болгох үйл ажиллагааны төлөвлөлт, гэр бүлийн хүчирхийллийн талаар үзүүлэх сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг хүргэсэн үр дүнтэй сургалт болов. “Эх дэлхийн цаг 2017” арга хэмжээг дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтдаа уриалгыг дэвшүүлэн 03 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд Дэлхийн байгаль хамгаалах сан, Өөр өнцөг гэрэл зургийн клуб, Залуучууд хөгжлийн төвийн дэргэдэх клубууд, аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлтэй хамтран орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийв. 5 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, 2 үйлчлүүлэгчийг шаардлагатай үйлчилгээнд хамрууллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нэгдсэн үндэстний байгууллагын хүн амын сангийн залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллага болох Иргэний боловсролын төвтэй хамтран “Залуучуудын асуудлаар үүрэг хүлээгчдэд зориулсан залуучуудын утга учиртай оролцоог хангах нь” сургалт зохион байгуулж тус сургалтанд Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдлаа.

Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд, багачуудад таниулах, сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх зорилгоор “Уран жиргээ” уран уншлагын тэмцээнийг 4 насны ангилалаар зохион байгуулж, тус арга хэмжээнд цэцэрлэгийн бага насанд 22 хүүхэд, ЕБС-ийн ын дунд насанд 25 хүүхэд, ахлах насанд 22 хүүхэд тус тус амжилттай оролцлоо.

Хүүхэд багачуудыг урлагийн амьдралд ойртуулах, ардын хөгжимтэй дуулах урлагт сургах, дууны утга санааг ойлгож мэдрэх, өвөг дээдэс, ард түмний дундаас уламжлагдан ирсэн ардын дууны өв сангаас суралцуулах, хүүхдийн дууны урын санг баяжуулах, мартагдсан дууг сэргээн өвлүүлэх, ирээдүйн авъяаслаг дуучдыг тодруулах зорилгоор “Дуулах өв-2017” тэмцээнийг зохион байгуулж, ерөнхий боловсролын 22 сургуулийн 66 авъяаслаг хүүхдүүд оролцов. Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүн болох 4 сурагч, Норвегийн тусламжийн байгууллагатай хамтран Баян-Өлгий аймгийн Ногоон нуур, Буянт сумын дотуур байрны хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагаа оролцоог идэвхжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллав.

Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, гэр бүлийн боловсролоор дамжуулан тогтвортой байдлыг хангаж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар гэр бүл, хүүхдэд ээлтэй орон нутаг болох зорилготой “Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг 2020 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийн хамт боловсруулж төрийн болон төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлж, санал авах ажлыг зохион байгууллаа.

**Хөдөлмөр нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлээр:** Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/319 дугаар тушаал, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/11 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын А/01 тушаалаар ажлын хэсгийг байгуулан нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах, одоо авч байгаа хэмжээг баталгаажуулах тэтгэвэр авагчдаас гаргасан өргөдөл, хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр 328 өргөдөл хүлээн авч шийдвэрлэн ажиллав.

Жаргалант сумын Засаг даргын 2017 оны А/55 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган хөрсийг хуурайшилтаас хамгаалах, чийг нэмэгдүүлэх, мөсжүүлэх арга хэмжээнд хамт олноороо идэвхи санаачлагатай оролцож, 72 айлын дээд талын зам дагуух цэцгийн мандалд мөс зөөж усалгаа хийв. Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний газрын дарга, нийгмийн халамжийн хэлтсийн дарга, мэдээлэл технологи хариуцсан ажилтан, өрхийн мэдээллийн сангийн судалгаа хариуцсан мэргэжилтнүүд “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тооцох судалгаа”-ны сургалтанд хамрагдаж судалгааны бэлтгэл ажил ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд сумдын хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтнүүд болон аймгийн төвийн 12 багийн нийгмийн ажилтнуудад судалгаанд хамрагдах өрхийн жагсаалт гаргах, газрын зураг бэлтгэх талаар сургалт зохион байгууллаа.

Тайлант сард ажил идэвхитэй хайгч 42 иргэнийг шинээр бүртгэж, 345 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүллээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMS программд бүртгэлтэй ажилгүй иргэд 2007 байна. Ажил идэвхитэй хайгчдаас 148 иргэнийг ажлын байранд зуучлан оруулав. Мөн шинээр бий болсон 25 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMS санд мэдээллийг шинэчлэв. Энэ сард 112 ажил олгогч аж ахуй нэгжээс 308 ажлын байрны захиалга ирж, 271 ажил хайгч иргэнийг ажилд зуучлан оруулсан байна.

Бүгд Найрамдах Солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдээс авах 13 дахь удаагийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг 03 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд хийв. Тус бүртгэлд нийт 215 иргэн бүртгэгдэж мэдээ тайланг ерөнхий газарт мэдээлэв. Шалгалтанд бүртгүүлсэн иргэдийг 03 дугаар сарын 27-ны өдрөөс солонгос хэлний анхан шатны сургалтанд хамруулахаар төлөвлөөд байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээг 18 иргэнд өгч ажиллав. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 262 500 төгрөг эргэн төлөгдөж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрсөн байна. Улсын төсвөөс 33.710.500 төгрөгийн санхүүжилт орсноос өмнөх оны өглөгт нийтийг хамарсан ажилд 17.577.600 төгрөг, ХБИ-ний ажил олгогчийн урамшилд 3.200.000 төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 6.660.000 төгрөгийн санхүүжилт хийгдэв. Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрт 2.670.000 төгрөг, гарын авлага, хэвлэмэл материалын зардалд 3.600.000 төгрөг тус тус зарцуулаад байна.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар цалин хөлсний зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хөдөлмөрийн бүтээмж тооцох, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн норм норматив тооцох, ажлын байрны үнэлгээ хийх, ажил мэргэжлийг бүлэглэх, зэрэглэх тус тус аргачлал болон цалин хөлсний бусад асуудлаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн бүтээмж тооцох хялбаршуулсан программыг нэвтрүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулж, хамтран ажиллах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн чиглэлээр төсөл хүлээн авах зарыг орон нутгийн телевизүүд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар түгээж төслүүдийг хүлээн авч байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 38 төсөл, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 40 төсөл, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн чиглэлээр 6

иргэний төслүүдийг хүлээн авч, Зорилтот бүлгийн иргэдийг байнгын ажлын байраар хангасан 2 ажил олгогчтой урамшил олгох гэрээ хийв.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, Startup Mongolia ТББ хамтран Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 110 хүн бүртгэж, шилдэг 50 бизнес санааг шалгаруулан 2017 оны 03 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд “STAR UP” сургалтын арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт шилдэг 10 бүтээлч санаа шалгарч, “Сум хөгжүүлэх сан”-ийн хөнгөлөлтэй зээл, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн зээл, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамрагдах эрхийн бичгээр шилдэг 8 бизнес санааг сонгон шагнаж урамшуулан хамтран ажиллаа.

Улсын төсвөөс нийт 1.496.850.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас, Алдарт эхийн одонд 1.230.000.0, Алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 17.000.0, Ахмадын “Насны хишиг”-т 249.850.0 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлсэн. Орон нутгийн төсвөөс 1.472.000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагааг санхүүжүүлж байна. Үүнд: Халамжийн тэтгэвэр 1786 хүнд 409.017.090 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1225 хүнд 195.487.280 төгрөг, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа 1480 хүнд 111.590.690 төгрөг, ахмад настны хөнгөлөлт, тусламж 2088 хүнд 88.600.920 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 1169 хүнд 428.840.200 төгрөг, жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 4059 иргэнд 146.784.070 төгрөг, ОНОТХҮйлчилгээ 201 хүнд 3.897.100 төгрөг, хүнс тэжээл хөтөлбөрт 147.201.400 төгрөг, Алдарт эхийн одонгийн тусламж 8067 хүнд 997.060.000 төгрөг, А алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 50 хүнд 15.339.700 төгрөгийг тус тус санхүүжүүллээ.

Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хөгжил Политехник коллеж болон Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Талх, нарийн боов үйлдвэрлэл”-ийн сургалтыг зорилтот бүлгийн иргэдэд амжилттай зохион байгууллаа. Мөн “Сайн эцэг, эх, Хүүхдийн эрх хөгжил хамгаалал, эрүүл мэнд”-ийн цуврал сургалтуудыг зохион байгуулан ажиллалаа.

Сумдын зорилтот өрхүүдэд хийгдэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд болон банк санхүүгийн байгууллагатай хамтран зохион байгуулан ажиллаж байна.

Хүн ам, ахмад настан, зорилтот бүлгийн хүрээнд “Цагаан-уул” ахмадын сувилалд амарч сувилуулж буй ахмадуудад “Насны хишиг” олгож байгаа мэдээллийг халамжийн WAIS программд шивж олголтын жагсаалтыг бэлтгээд байна. Аймгийн эмэгтэйчүүдийн чуулганд оролцох иргэдийн судалгааг 16 сумаас авч нэгтгэн аймгийн ЗДТГ-т хүргүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь сар бүрийн 2, 4 дүгээр долоо хоногийн пүрэв гаригт хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 12 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамруулахаар шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт Ортопедийн тусгай хэрэгсэл авах хэрэгцээтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрсийг халамжийн сангийн программд шалгаж 83 иргэнд ортопедийн туслах хэрэгсэл олгож WAIS программд бүртгэлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ирүүлсэн 4 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн иргэнд утсаар мэдэгдэж аймгийн Засаг даргын Тамгын газарт өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэв.

Баруун бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвд асруулж байгаа асруулагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, амьдарч буй орчинд нь сэтгэл хангалуун амьдруулах, итгэл үнэмшил төрүүлэх зорилгоор Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон цэргийн баярын өдрүүдээр асруулагчдад хүндэтгэл үзүүлэн баяр хүргэж, гарын бэлэг гардуулав.

Энэ сард 3 асруулагч Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэц, мэс засал, арьс харшлын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, эм, тарианд 162040, хоолонд 3909000, нормын хувцас, зөөлөн эдлэлд 1050900 төгрөгийг тус тус зарцуулсан. Ахмадын “Цагаан уул” амралт сувилалд 13 ахмад настан амарч 123 ор хоногийн 984.000 төгрөгийн орлого төвлөрүүлэн, амрагчдын дунд зохион байгуулах 10 хоногийн ажлын төлөвлөгөөг боловсруулав.

**Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр:** Монгол улсын хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын А/319 тоот тушаал, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/11 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын А/01 тушаалаар аян зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах, одоо авч байгаа хэмжээг баталгаажуулах тэтгэвэр авагчдаас гаргасан өргөдөл, хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулан нийт 328 өргөдөл хүлээн авч шийдвэрлэн ажиллаа.

03 дугаар сард 30 албан бичиг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан бөгөөд 24 албан бичгийг холбогдох газарт хүргүүлж 8 өргөдөл гомдол хүлээн авч 5 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна. Даатгуулагч иргэдэд 359 архивын лавлагаа гаргаж хэлтсийн сарын ажлын тайлан, мэдээг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж, цаг үеийн асуудлыг хэлэлцэн тодорхой шийдвэрүүд гарган биелэлтүүдийг тухай бүрт нь тооцон ажиллаж байна. Сайн дурын даатгалд 03 дугаар сард 4920 даатгуулагчийн 260.8 сая, эрүүл мэндийн даатгалд 1810 даатгуулагчийн 63.068 сая төгрөгийн даатгалын орлого тус тус төвлөрүүлэв.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг улсын 3 эмнэлэг, хувийн хэвшлийн 5 эмнэлэг, 28 эмийн сантай байгуулан Эрүүл мэнд нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан санхүүжилтийн хуваарийг гэрээнд тусгав. Бүсийн оншилгоо эмчилгээний төвд 4.080.0 сая, Булган сумын эмнэлэгт 485.7 сая, Мөст сум дундын эмнэлэгт 50.5 сая, хувийн хэвшлийн 5 эмнэлэгт нийт 403.1 сая, эмийн үнийн хөнгөлөлтөнд 600.0 сая, Элэгний “С”-вирусын эмийн үнийн хөнгөлөлтөнд 503.9 сая төгрөгний санхүүжилт батлагдсан байна.

03 дугаар сард 737 ажил олгогч 13008 даатгуулагч хамрагдаж, шимтгэлийн орлого 1.412 сая төгрөг төвлөрүүлэх тооцоотой байна. Өндөр насны тэтгэвэртэй 7315 хүнд 4.010.818.3, тахир дутуугийн тэтгэвэртэй 1488 хүнд 6.900.64.6, тэжээгчээ

алдсаны тэтгэвэртэй 766 хүнд 360.051.2–цэргийн тэтгэвэртэй 205 хүнд 238.616.0, үйлдвэрийн ослын тэтгэвэртэй 36 хүнд 26.454.7 мянган төгрөгийг тус тус зарцуулав.

Төрийн өмчийн хөрөнгийн жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 40 даатгуулагчид 44.091.5 мян төгрөг, Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмжийг 22 даатгуулагчид 1.909.6 мян төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжийг 145 даатгуулагчид 30.101.0 мян төгрөг, 11 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 11.000.000 төгрөгийг тус тус олгож зарцуулав.

Эмнэлгийн хөдөлмөр магадлалын Комиссын ээлжит хурлыг 03 дугаар сард 3 удаа хийж нийтдээ 177 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь болон хугацааны асуудлыг хэлэлцэж 121 иргэний актыг сунгаж, 14 иргэний актыг цуцалж ажилласан бөгөөд 41 иргэнд хугацааны актыг шинээр тогтоож, шилжиж ирсэн 1 иргэнийг мэдээллийн баазад бүртгэж авав. Энэ сарын байдлаар мэдээллийн баазад 3022 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

**Тав:Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:** Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулан орос, хятад хэлээр орчуулан бэлтгэлээ.

Аймгийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөл Засаг даргын захирамжаар байгуулагдан анхны хурлаа хийж, цаашдын ажлын талаар санал бодлоо солилцож, төлөвлөгөөнд тусгах саналыг холбогдох байгууллагуудаас авахаар шийдвэрлэв.

**Байгаль орчны чиглэлээр:** Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудын 4-8 дугаар ангийн сурагчдын дунд "Ус чандмань эрдэнэ" сэдэвт гар зургийн уралдаан, 8-12 дугаар ангийн сурагчдын дунд "Ус бидний нүдээр" эссэ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгууллаа. Тус тэмдэглэлт өдрийн хүрээнд "Ховд голын эргийг цэвэрлэх" ажлуудыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймгийн БОАЖГазар, УЦУОШГазар, Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, ХУНОУТХГНХЗахиргаа ХИС-тай хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд 80 оюутан оролцож Ховд голын эрэг дагуу 10 км, 50 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэж 10 тн хог хаягдлыг хогийн цэгт хүргэв.

"Хаврын бүтээлч аян"-ны хүрээнд "Хоггүй Ховд" бүх нийтийн цэвэрлэгээний арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 156 аж ахуйн нэгж, байгууллагын 1360 гаруй албан хаагчид болон Хөгжил Политехник коллежийн 750 гаруй оюутан, ерөнхий боловсролын 7 сургуулийн 620 гаруй сурагч, сумын 12 багийн 3250 орчим иргэн оролцож 201м<sup>3</sup> буюу 67 машин хог хаягдлыг цэвэрлэж ачиж зайлууллаа.

Мянгад сумын Цагаан булан багийн нутаг Хонгорж хэмээх газарт 2017 оны 03 дугаар сарын 08-ны өдөр орон нутгийн цагаар 15:30 минутанд Зэгсний түймэр гарч, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг мөн сумын ЗДТГ, хамгаалалтын захиргааны ажлын хэсэг, орон нутаг хариуцсан байгаль хамгаалагч 30 гаруй нутгийн иргэдийг дайчлан шуурхай арга хэмжээ авч зэгсний түймрийг газар авхуулалгүйгээр тогтоож 22:10 минутанд цурманд оруулан бүрэн унтраалаа.

Хаврын урь орж дулаарч байгаатай холбоотойгоор салхи, шуурганы давтамж нэмэгдэж хөрсөн дахь чийгийн хэмжээ багассанаар хуурайшилт бий болохоос гадна тоосжилттой холбоотой харшлын гаралтай өвчлөл үүсэх магадлал их байх тул дээрх байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хотын ногоон байгууламжийн хөрсний чийгийг нэмэгдүүлэх цэнэг усалгааг бүх аж ахуйн нэгж, албан байгууллагуудыг оролцуулан Жаргалант сумтай хамтран зохион байгуулсан нь үр дүнтэй томоохон ажил болов.

Аялал жуулчлалын салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхижүүлэх, Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, жуулчны улирлыг уртасгах, ирж буй жуулчдын тоог нэмэгдүүлэх, аймаг орон нутгаа давуу эрхтэйгээр сурталчлах зорилгоор "ITM-2017" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд түнш аймгаар оролцох бэлтгэл ажлыг ханган сурталчилгааны тараах материалууд, талбайн тохижилт, зохион байгуулалтын ажлын удирдамж, төлөвлөгөө боловсруулан аймгийн аялал жуулчлалын холбоо, соёлын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Мал эмнэлэг үржлийн газраас энэ онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх Мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд стандартын үзлэг аттестатчилал явуулахаар төлөвлөсөн зорилтын хүрээнд Мал эмнэлэг үржлийн газрын даргын даргын 26 дугаар зөвлөмж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны А/08 тоот тушаалаар сумдын Мал эмнэлэг үржлийн нэгжийн стандартын хэрэгжилтийг шалгаж аттестатчилах ажлын хэсэг байгуулагдан 2017 оны 3 дугаар сарын 13-19-ний өдрүүдэд 17 суманд үйл ажиллагаа явуулж буй 55 Мал эмнэлэг үржлийн нэгжийг батлагдсан стандартаар, мал эмнэлэг үржлийн тасгийг Хүнс, хөдөө аж ахуйн газраас боловсруулсан 34 заалт бүхий ажлын үзүүлэлтээр шалгав.

Стандартын хэрэгжилтийн дүнгээр манай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа шалгалтанд хамрагдвал зохих 55 мал эмнэлэг үржлийн нэгжээс 37 нэгж буюу 67,3 хувь нь үзлэгт хамрагдаж, 18 нэгж буюу 32,7 хувь нь шалгалтанд хамрагдаагүй буюу шалгалтын шаардлага хангаагүй байна. Үзлэг шалгалтанд хамрагдсан 37 нэгжээс 5 нэгж буюу 13,5 хувь нь 700-аас дээш оноо авч, "А" үнэлгээтэй, үүнээс 3 нэгж нь мал эмнэлгээс гадна мал үржлийн үйл ажиллагааг хамт эрхэлдэг, 21 нэгж буюу 56,7 хувь нь 551-ээс дээш оноо авч "В" үнэлгээтэй, үйл ажиллагаа нь тогтмолжоогүй, 11 нэгж буюу 29,7 хувь нь 550-аас доош оноо авч "С" үнэлгээтэй стандартын шаардлага хангаагүй гэж тус тус дүгнэгджээ. Өөрөөр хэлбэл тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 55 мал эмнэлэг үржлийн нэгжээс 26 нь буюу 47,2 хувь нь стандартын шаардлагыг хангаж, үлдсэн 29 нэгж буюу 52,7 хувь нь шалгалтанд тэнцээгүй буюу стандартын шаардлага хангаагүй байна.

Мал амьтны Колибактериоз халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 23.2 мянган малд хийхээс 23.0 мянган толгой малд хийв. Буянт сумын Нарийн гол багийн малчин Нямбаярын хотонд 2 үхэр галзуу өвчнөөр өвчилсөн мэдээллийг авч голомтын бүсэд байгаа 2500 толгой малыг вакцинжуулалтанд хамруулаад байна.

ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэнгээр ахлуулсан ажлын хэсэг 3 дугаар сарын 23-ны өдөр манай аймагт ажиллаж Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөл байдалтай танилцав. Энэ үеэр газрын удирдлага

лабораторийн байрыг засварлах хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэж өгөхийг уламжлав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2005 оны 35 дугаар тушаалаар батлагдсан Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий, эд бүтээгдэхүүнд мал эмнэлэг ариун цэврийн баталгаажуулалт хийх, гарал үүслийг тодорхойлох заавар журмын дагуу Мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээг сумдад хуваарилж, хуваарийг нэгтгэн олгоход бэлэн болов.

Малын халдварт өвчний тандалт шинжилгээ хийн түүн дээр үндэслэн заавар зөвлөмж гаргах үүднээс Булган сумын Алаг толгой багийн ямаа, Баянгол багийн үхрийн эмгэгт /материалд/ нян судлалын шинжилгээ хийж, шинжилгээгээр колибактериоз өвчний үүсгэгч илэрсэн бөгөөд онош баталгаажуулахаар дээжийг Улсын мал эмнэлэгийн төв лабораторид хүргүүлээд байна.

Жайка ОУ-ын байгууллагын Монгол улсын Хөдөө аж ахуйн салбарын суурь судалгааны төслийн багийнхан манай аймагт ажиллаж, мал аж ахуй, газар тариаланд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нөхцөлийн талаар малчид, тариаланчид, махны үйлдвэр, мах, төмс, хүнсний ногоо худалдан борлуулагчид, жимс жимсгэнэ тариалагчидтай 2017 онд тариалан эрхлэлтийг эхлүүлэх, тариаланчдад заавар зөвлөмж өгөх зорилгоор 03 дугаар сарын 23-ны өдөр уулзалт зохион байгуулав.

Аймгийн хэмжээнд мал төллөлт 3 дугаар сарын 30-ны байдлаар нийт 217 370 хээлтэгч төллөж, 211787 төл бойжиж байгаа мэдээтэй байна. Үенч сумын Цагаан түнгэ багийн малчин Д.Отгонбаярын хотонд ямаа ишиглэж 5 ихэр ишиг, Манхан сумын Улаанхүрээ багийн малчин Х.Нямсүрэнгийн тэмээн сүрэгт 3 дугаар сарын 29-ний өдөр ингэ ботголж ихэр ботго тус тус гарлаа. Төл бойжилт болон малын зүй бус хорогдлын мэдээг ХХААХҮЯам, Улсын Мал эмнэлэг, үржлийн газар зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.

**Зам тээврийн чиглэлээр:** Манай аймагт энэ сарын 21-23-ны өдрүүдэд их хэмжээний цас орж тээврийн хэрэгсэл явахад хүндрэл гарч гуу жалгаар хунгарласан цасыг “Ховд АЗЗА” ТӨХК ХГ 31802-1 автогрейдрээр хусаж цэвэрлэв. Ховд-Булган чиглэлийн 16 км хайрган замын дагуух ус дамжуулах хоолойн орох, гарах амсрын таглааг авч шар усны үерийн усыг зайлуулах нөхцлийг бүрдүүлсэн.

“Ховд АЗЗА” ТӨХК А14 дугаартай Булган-Улсын хил чиглэлийн зам, Ховдоос 120-145 км-т Хавчигийн хавцалд хунгарласан цасыг 836 маркийн ачигчаар, Бага улаан давааны орчмын замд 1м гаруй зузаан цас хунгарлаж тээврийн хэрэгсэл явах боломжгүй болсныг ковшоор хутгаж зайлуулав. Мөн Бодончийн хавцлын замын дагуу хунгарлаж тогтсон цасыг GR-165 автогрейдрээр хусаж цэвэрлэн тээврийн хэрэгслийн аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэн ажиллав.

Аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, "Ховд аймгийн авто тээврийн төв" УУГазартай хамтран Улсын болон Олон улсын чанартай авто замын тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж Алтай, Үенч, Булган, Манхан, Зэрэг, Дарви, Буянт, Мянгад сумдад ажиллаа.

Увс аймгийн Харганатын төмрийн хүдрийн ордоос даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж байсан 14 хүнд даацын тээврийн хэрэгслийг саатуулан хяналт хийж, шаардлагатай арга хэмжээг авч Засаг даргын А/86 захирамжийн биелэлтийг хангаж ажиллав.

**Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:** Жаргалант сумын 1 дүгээр бүсэд оршиж байгаа газар эзэмших зөвшөөрөлтэй 40 граж, зөвшөөрөлгүй гражийн газар ашиглаж байгаа 307 иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж ARCGIS программ дээр зураглан мэдээллийн санд оруулав. Аймгийн хэмжээнд газар өмчилсөн иргэдийн мэдээллийн сангийн программд оруулах мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж хүргүүлсэн. Мөн 42 иргэний газрын кадастрын зураг гаргаж, иргэдийн асуусан асуултанд холбогдох мэдээллийг өгч ажиллав.

### **Зургаа. Сумдын мэдээлэл:**

**Жаргалант сум:** Онцгой байдлын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийнхантай хамтран гамшгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, галын аюулгүй байдлыг хангах талаар багийн Засаг дарга болон нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгууллаа. Мөн багийн Иргэдийн Нийтийн хурал хуралдаж 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Сумын ИТХ-ын нийгмийн бодлогын хороотой хамтран ажил үйлсээрээ манлайлан ажиллаж байгаа шилдэг тэргүүний ээжүүдийг шалгаруулан алдаршуулж, “Ээжийн бүүвэйтэй хорвоо” дуун цэнгүүнийг зохион байгуулав.

Мал сүргийг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд коли ижбалнад, ДХХ, галзуу, шөвөг ярын вакциныг аймгийн ХХААГ-аас татан авч хувьчлагдсан мал эмнэлэг, үржлийн нэгжүүдэд хуваарилан өгч тарилга хийгдэж эхлээд байна.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн ХХААГ-аас Буянт, Ховд, Жаргалант сумдын тариаланчдын дунд тариалалтанд хэрхэн бэлтгэх цаашид анхаарах асуудлын талаар туршлага солилцох уулзалтыг зохион байгуулж, тэдний санал сэтгэгдлийг сонсов. Сумын хэмжээнд төл бойжилтийн явц 20 гаруй хувьтай, төл бойжилтийн мэдээг тухай бүр ХХААГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Газрын цахим мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй орсон иргэдийн мэдээллийг шинэчлэх, газрын зөрчил арилгах ажлыг гүйцэтгэх ажлын хэсэг байгуулагдан иргэн, аж ахуй нэгж байгууллагын мэдээллийн зөрүүг баталгаажуулан ажиллаж байна. Мөн Жаргалант сумын нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулахад баримтлах журмыг шинэчлэн боловсруулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.

Аймгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний шийдвэрийн дагуу “Хоггүй Ховд” бүх нийтийн цэвэрлэгээний арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хар-ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, Цаг уур орчны шинжилгээний газар, Сум дундын Ойн анги, “Эрч хүч” ОНӨААТҮГазруудтай хамтран зохион байгуулж тус арга хэмжээнд 96 аж ахуйн нэгж, байгууллагын 680 гаруй албан хаагчид, Политехник коллежийн 750 гаруй оюутан, ерөнхий боловсролын 7 сургуулийн 320 гаруй сурагч, сумын 12 багийн 1100 орчим иргэд оролцож, 69м<sup>3</sup> буюу 23 машин хог хаягдлыг хогийн цэгт ачиж зайлуулав.

Хөрсийг хуурайшилтаас хамгаалах зарим арга хэмжээний тухай сумын Засаг даргын 2017 оны А/55 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хөрсөнд

чийг нэмэгдүүлэх, мөсжүүлэх аяныг зохион байгуулж, 41 аж ахуйн нэгж, байгууллага оролцож өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайд 450 машин буюу 1350м<sup>3</sup> мөс тавьсанаар хөрс чийгтэх боломж бүрдлээ.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн салбар, сумын ЗДТГ хамтран ерөнхий боловсролын сургуулийн ЭКО клубын сурагчдын дунд “Ногоон хөгжилд бидний оролцоо” сэдэвт сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд дээрх үйл ажиллагаанд 7 сургуулийн 35 сурагч оролцож, хамтрагч байгууллагаас ЭКО клубын гишүүн сурагч бүрт гарын бэлэг гардуулав. 4 сарын мэдээтэй давхацсан мэдээлэл.

**Буюнт сум:** Улсын бүртгэлийн ажиллагааг онлайн горимд шилжүүлж үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэнд эрх зүйн үйлчилгээг ойртуулах зорилгоор “Нэг иргэн, нэг бүртгэл” сэдэвт нээлттэй хаалганы өдрийг 3 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж TV9 телевизийн орон нутгийн info мэдээллээр нийтэд хүргэж дамжууллаа. Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Хоролсүрэнгээр ахлуулсан ажлын хэсгийнхэн иргэний бүртгэлийн ажил байдалтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч “Иргэний бүртгэлийн өнөөгийн байдал, цаашдын шинэчлэл” сэдвээр мэдээлэл хийв.

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газар болон сумын эмэгтэйчүүдийн холбооноос 10 алдартан ээжүүдээ шалгаруулан хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа. “Энэрэлт ээж”-ээр Х.Янжмаа, “Саран ээж”-ээр Т.Өлзийхүү, “Ачлалт ээж”-ээр О.Отгон, “Наран ээж”-ээр Г.Пагмажав, “Буюнтай ээж”-ээр Г.Буянаа, “Оюунлаг ээж”-ээр Н.Булгаа, “Манлай ээж”-ээр В.Доосмоо, “Дархан ээж”-ээр А.Казифа, “Халамжит ээж”-ээр Т.Тилеубай, “Хөдөлмөрч ээж”-ээр Э. Аюуш нар тус тус өргөмжлөгдөв.

Казак ард түмний Наурыз хаврын баярын үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд иргэдийн дунд “Наурыз бике” тэмцээн болон “Айтыс” харилцаа дууны наадмыг зохион байгуулж, байр эзлүүлэн шагнаж урамшуулав.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2013 оны А/106 дугаар захирамж гарч Онцгой байдлын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, албадуудын бие бүрэлдэхүүн 3 дугаар сарын 26-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газартай хамтран гамшгийн аюулын зарлан мэдээг хүргэх, ард иргэдэд гамшгийн аюулын зарлан мэдээллийг үүрэн холбоогоор хэрхэн дамжуулах дадлага сургуулалт хийж тус арга хэмжээнд аж ахуйн нэгж, албан байгууллагууд, ард иргэд идэвхитэй оролцов.

**Алтай сум:** 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр 12 жилийн дунд сургуулийн хүнсний бүтээгдэхүүн болон “Үдийн цай” нийлүүлэх тендерт оролцсон аж ахуйн нэгж байгууллагын тендер шалгаруулалтыг сумын Засаг даргын орлогч Б.Алтангэрэлээр ахлуулсан үнэлгээний хороо хариуцан явуулж тендерт “Хавтаг Алтай” ХХК, “Оцог хад” хоршоо, “Алтайн тэмүүлэл” ХХК тус тус шалгарч хамтран ажиллах гэрээг сургуулийн удирдлагатай байгуулав.

Хил хамгаалах туслах хүчний орон тооны бус салбар зөвлөл, Хилийн цэргийн 0130 дугаар анги хамтран 2016 онд хийсэн ажлаа тайлагнаж, 2017 онд хийх ажлын төлөвлөгөөгөө батлав. Өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоох судалгааны ажил зохион байгуулах бэлтгэл ажил хангаж 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн сумын хэмжээнд тооллогын 3 хэсэг ажиллаж эхлээд байна.

“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК айл өрхүүдийн тоолуурыг гадна шонгийн модонд байршуулах, шугамын алдагдлыг бууруулах ажлын хүрээнд сумын эрчим хүчний ажилтантай хамтран ажиллав. Мөн аймгийн Хүнс, ХАА-н газрын малын их эмч Ю.Энх-Амгалангаар ахлуулсан ажлын хэсэг сумын хувийн мал эмнэлэг, мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр шилдэг 9 ээжүүдийг шалгаруулж, шагнаж урамшуулав. “Дархан ээж”-ээр Тахилт багийн өндөр настан Д.Эрдэнэчимэг, “Манлай ээж”-ээр Бодонч багийн иргэн Ч. Жавзандулам, “Буянт ээж”-ээр Тахилт багийн өндөр настан Ж.Хорлоо, “Оюунлаг ээж”-ээр Бодонч багийн өндөр настан Ц.Мядаг, “Энэрэлт ээж”-ээр Тахилт багийн өндөр настан Ч. Ембүү, “Ачлалт ээж”-ээр Алтангадас багийн өндөр настан Ч. Дуламжав, “Наран ээж”-ээр Алтангадас багийн өндөр настан Т.Хөхөө, “Халамжит ээж”-ээр Алтангадас багийн өндөр настан Т.Цэвээн нар тус тус шалгарч өргөмжлөгдөж, “Сандаг сан”-аас Бодонч багийн өндөр настан Н.Бадамхорлоо, Тахилт багийн өндөр настан С.Нина, бага ангийн багш Т.Бямбасүрэн, дунд ангийн багш О.Бямбасүрэн, Барлаг багийн иргэн Ч.Энхтуяа нарт хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулав.

Монгол улсын Засгийн газрын 339 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор урьдчилан тогтоосон 4 цэгт үзүүлэх сургалтыг 03 дугаар сарын 23-ны ий өдрийн 15 цагт сумын хэмжээнд амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 150 өрхийн төлөөлөл 304 иргэд, 47 машин, 22 мотоцикл, 9 унадаг дугуй тус тус хамрагдав.

**Булган сүм:** Эх орончдын баяраар эрэгтэй, эмэгтэй волейбол, шатар, чансаа өндөр бөхчүүдийн тойргийн барилдаан зэрэг спортын арга хэмжээ зохион байгуулагдаж 200 гаруй иргэд хөдөлмөрчид оролцов.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр сумын тэргүүний 9 ээжийг шалгаруулж алдаршуулав. “Манлай ээж”-ээр Нукаан Эрдэнэцэцэг, “Ачлалт ээж”-ээр Жумбаан Буяа, “Энэрэлт ээж”-ээр Нямаан Балжинням, “Дархан ээж”-ээр Закарияан Зардбай, “Буянтай ээж”-ээр Салзадын Бадам, “Наран ээж”-ээр Хонгорын Эрдэнэбулгаа, “Саран ээж”-ээр Д.Жавзанпагма, “Халамжит ээж”-ээр Олзвойн Богширго, “Оюунлаг ээж”-ээр Равжаан Цэцгээ нар тус тус өргөмжлөгдөв.

Хил хамгаалах туслах хүчний орон тооны бус зөвлөлийн гишүүд хуралдаж, хилийн бүсэд тулгамдаж буй асуудал, цаашид хийгдэх ажлын талаар санал бодлоо солилцон 2017 оны ажлын төлөвлөгөөг баталлаа.

Монгол цэргийн баярыг тохиолдуулан “Монгол улсын тусгаар тогтнолын төлөө Булган нутгийн эх орончдын оруулсан гавьяа” арга хэмжээг зохион байгуулж 100 гаруй иргэд хөдөлмөрчид оролцлоо. Монгол улсын баатар Баясгалангийн Бадам, Энхийн Шилэг нарын хөшөөнд цэцэг өргөх ёслол болж, нутаг орныхоо түүхээ мэдэх, нутаг орноороо бахархах бахархалыг төрүүлэх үүднээс тус үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургуулийн 147 сурагчдыг хамруулав. Түүнчлэн хил хамгаалах их үйлсэд өөрсдийн сэтгэл зүрхээ зориулан ажиллаж байсан ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэв.

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаанаас “Дэлхийн усны өдрийг” тохиолдуулан “Ус ба ирээдүй” сэдэвт гар зургийн уралдааныг 1-5 дугаар анги, 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж, тус арга хэмжээнд 170 гаруй сурагчид хамрагдлаа.

Улаанбаатар хотод болсон Нутгийн зөвлөлийн золголтонд сумын удирдлагууд оролцож цас зудтай хүнд байсан үед тусламжийн гараа сунгасан нутгийн зон олондоо баярлаж талархаж байгаагаа илэрхийлэн Минжит булган нутгийн зөвлөлөөс өгсөн

хандивын 22 сая төгрөгийн зарцуулалтын болон 2016 онд хийж хэрэгжүүлсэн ажил, 2017 оны ажлын төлөвлөгөөг тус тус танилцуулж ажиллалаа.

Наурызын баярын арга хэмжээнд УИХ-ын гишүүн О.Батнасан, аймгийн ИТХ-ын төлөөлөгч Х.Бат-Эрдэнэ нар оролцож, 2016 оны ажлаараа тэргүүлсэн 9 алдартны шагналыг гардуулан өгч баяр хүргэв.

**Манхан сум:** Сумын ЗДТГ, сумын эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран өргөмжлөлт 9 ээжийг шалгаруулж, хүндэтгэл үзүүлэв. Алтайн Захчины Раашганзэглин хийд захчин түмний их шүтээн Алтан Майдар эргэх ёслолын арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга болон Засаг дарга нар оролцож иргэд, сүсэгтэн олонд талархал илэрхийлэв.

Аймгийн Онцгой байдлын газрын гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилт болон Улсын бүртгэлийн хэлтсийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг амжилттай зохион байгуулж, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулав.

Цөм хөтөлбөрийн сургалтанд цэцэрлэгийн эрхлэгч, багш нар хамрагдаж “Босоо заяатай Монгол” цэцэрлэгийн насны хүүхдийн бөхийн барилдаан болон уран жиргээ тэмцээнд амжилттай оролцож, багш нар бүтээлийн үзэсгэлэн гаргав. Мөн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа 5 настай хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулан хянуулахаар Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлэв.

Эрүүл мэндийн төв нь 4 их эмч, 22 ажилтан, нийт 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 03 дугаар сарын 24-ний ы байдлаар 698 хүнд үзлэг шинжилгээ хийж, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 273 хүн хамруулсан ба 47 өвчтөн хэвтэн эмчлүүлж, стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчилж байна. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 43 хүүхэд хамруулж, 6 эхийг эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 11 дуудлаганд үйлчилсэн байна. Мөн 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд байнгын хяналт тавин ажиллаж байна.

03 дугаар сарын 11-ний өдөр Баянгол багийн ар хөдөө өвдсөн байх магадлалтай нэг бөхөн явж байна гэсэн мэдээллийн дагуу Баянгол багийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Хороон үзүүр, Адгийн худаг, Дугуйн ам, Талын толгой, Булангийн овоо, Улаан бух, Өөшийн хөдөө, Өөшийн ангис зэрэг газруудаар ажиглалт, тандалт судалгаа, хяналт шалгалт хийхэд сэжигтэй зүйл илрээгүй болно.

**Мөнххайрхан сум:** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, мал аж ахуйн салбартай холбоотой төрийн хууль тогтоомж, бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, цаг үеийн ажлын мэдээ мэдээллийг малчин, мал бүхий иргэдэд сурталчилан таниулах зорилгоор “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд 143 малчин оролцож, мал маллагааны арга ухаан, тэргүүн туршлагаасаа хуваалцан санал бодлоо солилцож, баг тус бүрээс тэргүүний малчныг шалгаруулан урамшуулав.

Сумын ЗДТГ, “Хатан Сэнхэр” эмэгтэйчүүдийн ТББ хамтран эмэгтэйчүүдийн баярын хурал, эхчүүдийн алдар тэмдэглэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2013 оны А/106 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор хэрхэн ажиллах дадлага сургуулийг хийж аж ахуйн нэгж, албан байгууллагын 266 хүн хамрагдав.

Сумын түүхт 90 жилийн ойг угтаж 90 бүтээлч ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар

батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн долоо хоног бүрийн Пүрэв гарагийг бүтээлч ажлын өдөр болгон зарлаж, 7 хоног бүр бүтээлч ажлын өдөртэй болов.

**Мөст сүм:** Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор төрийн болон төрийн бус байгууллагуудын 113 хүн, 12 техник хэрэгсэл оролцож хээрийн үүргэвчний бүрэн байдал, аврах үйл ажиллагааны үзүүлэх сургуулилтыг хийж байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах чадварыг ахиулсан үр дүнтэй ажил болов.

Сургуулилтаар гамшгийн тухай мэдээлэл, цас зуднаас сэргийлэх талаар өнгөрсөн жилийн мялзан малын гоц халдварт өвчний талаар сургамж авах усны ай сав газар, ам тосож нутаглахгүй байх талаар ард иргэд, малчдад хүргэх ярих талаар сэрэмжлүүлэг хийлээ.

Төсвийн зарцуулалтанд анхаарах асуудлаар албан газрын дарга, ня-бо нарт зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна. 2016 оны жилийн эцсийн орон нутаг болон төсөвт байгууллагуудын санхүүгийн нэгдсэн тайлангийн тодруулга тайлан гаргаж 03 дугаар сарын 12-ны өдөр Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.

03 дугаар сарын байдлаар татварт 2333.0 мянган төгрөг төвлөрөхөөс 312.4 мянган төгрөг төвлөрч 2.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь суутгагчийн хувь хүний орлого, үйл ажиллагааны орлого төлөвлөгөө өндөр тогтсонтой холбоотой гэж үзэж байна. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 5 даатгуулагч хамрагдсан ба нийт 27 даатгуулагчийн 1945.9, эрүүл мэндийн даатгалд 24 даатгуулагчийн 752.7, нийгмийн даатгалын шимтгэлээр 5 байгууллагын 12965.9, нийт 15664.9 мянган төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 91 хувьтай байна.

Сангаас 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 100148.8 мянган төгрөг, тэтгэмжинд 4485.4 мянган төгрөг, нийт 104634.2 мянган төгрөг тавьж олгосон ба тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 8 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 2 даатгуулагч тэтгэвэр тогтоолгов. Тэтгэврийн өөрчлөлтийг 1 тэтгэвэр авагч хийлгэж, шинээр төрсөн хүүхэд 5, шинээр гэр бүл 3, нас барсан 2, шилжиж ирсэн 18, шилжиж явсан 2 иргэн байна.

Нийгмийн халамжийн сангаас 45 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сар бүр 140.0 төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмж 12, хүүхэд, ахмад настны асаргаанд 58 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаанд 18 хүн, хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдийн асаргаанд бүтэн өнчин буюу асрамжинд байгаа 3 хүүхэд, 16 дээш насны хөгжлийн бэрхшээлтэй 10 хүний эм тарианы үнэнд, 18 ахмад настан, 16-аас доош насны 10 хүүхдэд эм тарианы үнэнд 140.0, 2 ахмад настны шүдний хөнгөлөлтөнд 240.0 мянган төгрөгийг тус тус халамжийн сангаас олгогдов.

Нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан байнга оршин суудаг ахмад настан аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардал олгох хуулийн дагуу 2 хүнд 130.0 төгрөгийн хөнгөлөлтийг аАмьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж олгов. Асаргаанд орох хүсэлтэй 5 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн 3 өргөдлийг шийдвэрлүүлж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.

Байгаль орчны салбарт 2017-2020 онд хийж гүйцэтгэх ажлын болон хяналт шалгалтын график төлөвлөгөөг боловсруулан Тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн дунд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж 5 тэвш буюу 8 тн хогийг хогийн цэгт хүргэж ажиллав. “Мянган угалзатын тусгай хамгаалалтай газар”-ын захиргаатай хамтран сумын үзэсгэлэнт түүх соёлын дурсгалт газрыг

хаягжуулж байна. Газар зохион байгуулалтын чиглэлээр 21 өргөдөл хүсэлтийг хүлээн авч өвөлжөө, хаваржааны зориулалтаар 2 иргэнд 0,3 га газрыг олгож, эзэмшүүлэх гэрчилгээ олгож улсын бүртгэлд бүртгэв.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр сумын эмэгтэйчүүдийн зөвлөл, багийн Засаг дарга, ИНХ-тай хамтран эмэгтэйчүүдийн дунд урлаг соёлын олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж, хүндэтгэл үзүүлэв. Мөн сургуулийн ой угтсан арга хэмжээний хүрээнд багш сурагчдын хамтарсан урлагийн тоглолтыг сум, аймаг, Улаанбаатар хотноо зохион байгуулж, ойг тэмдэглэн өнгөрүүлэх хандивын санд 70.0 сая төгрөг төвлөрүүллээ. Ойн хүрээнд 11 төрлийн ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл 98 хувьтай байна.

Сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтаар Улаантолгой багийн 59, Цэцэг гол багийн 21, Хужирт багийн 11, Баянхайрхан багийн 8, Давст багийн 3 нийт 100 гаруй хүүхдэд бага боловсрол олгов.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Уран жиргээ-2017” яруу найргийн наадам, “Босоо заяатай Монгол” үндэсний бөхийн барилдааныг амжилттай зохион байгуулав.

Эрүүл мэндийн төв нь 431 хүнд үзлэг шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт 180 хүн хамруулсан ба 47 өвчтөн хэвтэн эмчлүүлж, алсын дуудлаганд 19, товллын дархлаажуулалтын хамрагдал 95 хувьтай, 2 эхийг эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 12 дуудлаганд үйлчилсэн байна. Эмнэлгийн ажилчдын дотоодын сургалтыг 2 удаа зохион байгуулав.

**Эрдэнэбүрэн сум:** Багуудын ИНХ 03 дугаар сарын 07-14-ний өдрүүдэд хуралдаж багийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, багийн хүний эмч, малын эмч нарын 2016 оны ажлын тайланг хэлэлцэн баталлаа. Сумын ЗДТГ, эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран ажил үйлсээрээ манлайлсан 10 алдарт ээжийг шалгаруулан алдаршуулж, гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулав.

03 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд “Өөлдийн таван шүтээн”-ний тахилга, “Цамбагарав хайрханы хишиг” үндэсний бөхийн барилдаан, “Төвийн бүсийн хурдан морьдын уралдаан”-ыг амжилттай зохион байгууллаа. Мөн “Малчдад туслах сайн үйлсийн аян” өрнүүлж сумын төрийн албан хаагчид, банкны ажилтнууд, аж ахуйн нэгжийн удирдлагууд, ТББ-ын тэргүүн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид 115 хурганы уут, ЕБС-ийн сурагчид 120ш элгэвч оёж өгч малчдад гардуулан өглөө.

Казах түмний Наурыз буюу нарны баяраар 80-аас дээш настай 2 ахмад, өндөр настай 11 ахмадад гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүллээ. Сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдэд үйлчлэх “Угтах үйлчилгээ”-г сумын Засаг даргын Тамгын газарт шинээр нэвтрүүлж, нээлтийн арга хэмжээг орон нутгийн болон төвийн телевизүүдээр мэдээлж сурталчлав.

Сумын Залуучуудын чуулга уулзалтын удирдамжийг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж бэлтгэл ажлыг хангаж эхлээд байна. “Архи, тамхигүй-Эрдэнэбүрэнчүүд” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх сумын төлөвлөгөө баталж хэрэгжүүлж байна. 03 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд сумын төвийн 2 га газрын нүүрсний үнс, нурсан балгасын суурь, элс 400 тн-ыг ачиж зайлуулан хогийн төв цэгт 350 м газар далан байгуулж тохижуулав.

Сумын ИТХ-ын 4 дүгээр хуралдаанаар сумын газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт, цаашид тавих зорилтын тухай, орон нутгийн байгалийн баялагийн дагалдах баялаг болон зарим хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай, Төлөөлөгчийн өргөдөл хэлэлцэх тухай асуудлыг тус тус хэлэлцэн батлав.

“Эх дэлхийн цаг” арга хэмжээний хүрээнд “Лаануудаар аль байгууллага, баг хамт олон зөв оновчтой санаа гаргах вэ?” уралдаант тэмцээн зохион байгуулж уг арга хэмжээнд 96 хүн, 30 хүүхэд оролцсоноос ЭМТ-ийн ажилчид 1 дүгээр байр эзэлж 20000 төгрөг, Хаан банкны хамт олон 2 дугаар байр эзэлж 10000 төгрөгөөр шагнагдав. Тэмцээнийг Хар-Ус багийн иргэн Н.Дашдорж ивээн тэтгэж шагналыг гардуулав.

Сумын уугуул генерал Л.Баябазар, бригадын генерал Т.Хүрэлбаатар нар санаачлан “Нутгийн генералуудын хишиг” шагналыг цэргийн алба хааж буй сумын Шураг багийн залуу Б.Болдбаатарт гардуулж 14 хоногийн орон нутгийн чөлөөгөөр шагнасан нь батлан хамгаалах үйл ажиллагааг сурталчилсан тэмдэглэлт ажил боллоо.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор дадлага, сургалт зохион байгуулж 93 хүн, 175 хүүхэд 12 автомашин, 5 мотоцикл оролцов. Соёлын төв нь 8 нийтийг хамарсан 8 ажил үйлчилгээ гүйцэтгэж, нийт 1392 үйлчилгээ үзүүлсэн байна.

**Мянгад сүм:** Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 2 удаа хуралдаж сумын Хүндэт тэмдгийн үнэ санхүүжүүлэх, алдарт эхэд одон олгох, хөрөнгө зарцуулах, Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны зурагт болон ухуулах хуудас байрлуулах, гудамж талбай олон нийтийн газрын байршлыг тогтоох, Чацарганат багийн Их түймэрт газрын маргааныг тус тус шийдвэрлэн баталлаа.

Тус сумын нутагт 03 дугаар сарын 21-ний шөнөөс эхлэн 48 цаг үргэлжлэн цас орсон улмаас Баянбулаг багт гамшгийн хэмжээнд хүрсэн ба сумын Онцгой комисс шуурхай хуралдан гамшгийн үеийн дайчилгаанд нийт 17 хүнийг тус багт ажиллуулж, сумын нөөцөөс эхний ээлжинд 500 пресс өвсийг, дараагийн ээлжинд аймгийн Онцгой байдлын газарт уламжлан Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн техник хэрэгсэл ашиглан зам гаргаж 900 гаруй ширхэг пресс өвсийг тус багт хүргүүлээд байна.

Байгууллага, иргэдээс нийт 8 өргөдөл, гомдол хүлээн авч хуулийн хугацаанд хариуг өгч шийдвэрлэв. Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд тэжээгчээ алдсаны тэтгэмжийн 13 иргэнд 1820.0, хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэртэй 65 иргэнд 15600.0, ахмад настанг асарч буй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэжийн 46 иргэнд 2944.0, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжийн 51 иргэнд 12240.0 мянган төгрөгийн тэтгэмж тус тус олгосон байна.

Шимтгэлийн орлого 24150.1, иргэний сайн дурын даатгалд 31 иргэнээс 2110.1, , эрүүл мэндийн даатгалд 29 иргэнээс 1135.0, ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлд 1 иргэнээс 78.1, нийт 27473,3 мянган төгрөгийн орлого орууллаа. Мөн 6 иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлэн тэтгэврийн тогтоолт хийв. “Ажилласан жил тэтгэврийн даатгал нөхөн тооцох хууль”-ийн хүрээнд жил тооцуулах хүсэлт ирүүлсэн 2 иргэний өргөдлийг хүлээн авч нэмэгдлийг аймгийн тэтгэврийн мэдээллийн баазад оруулах санал хүргүүлж тогтоолт хийж баталгаажуулав.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 100223.1 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 281 хүнд 79350.7, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 33 хүнд 5926.7, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 75 хүнд 12160.7, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд 302.3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тус тус олголоо.

03 сард төрөлтийн 5, гэрлэлтийн 2, гэрлэлт цуцлалтын 1, нас баралтын 4, шилжин явсан 5, шилжин ирсэн 4 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. Эрүүл мэндийн төв нь нийт 216 амбулаторийн үзлэг хийж 32 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 21 алсын дуудлаганд явж, 4 жирэмсэн эхийг хяналтанд авч, товлалтын дархлаажуулалтыг 8 хүүхдэд хийж үйлчилсэн.

Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан мэргэжилтэн, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээг шинэчлэн баталж, ажил үүргийн хуваарийг нягтруулан ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсрууллаа. Малын халдварт өвчин болон тал төллөлт, бойжилт, мал хорогдлын мэдээг 7 хоног бүр мэдээлж байна. 2016 оны ноосны урамшуулалд хамрагдах иргэдийн данс хаагдсан болон бусад зөрчлийг арилгаж мэдээллийг аймгийн ХХААГ-ын МАА-н хэлтэст хүргэлээ.

БОАЖЯ-ны сайдын А-22 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас зориулалтын аргаар нууруудын загасны сүргийн бүтцийг зохицуулах, нөхөн төлжих чадвар муутай, ахимаг насны загасыг жилд 50 тн хүртэл мэргэжлийн байгууллагаар олборлож заазлах агнуур явуулах шаардлагатай гэсэн зөвлөмжийн дагуу Мянгад сумын Засаг дарга, Хар-Уус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга, “Найман-Од” ХХК-ний гурвалсан гэрээгээр сумын иргэдийн оролцоотойгоор 2000 ширхэг Алтайн сугас загас барих, гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээг байгуулав. Гэрээний дагуу сумын байгаль хамгаалагч, байгаль орчны үлээн хяналтын улсын байцаагч нар загас барьж буй иргэдэд хяналт тавих, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах зорилгоор Гахайт багийн нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийж ажиллаа. Хяналтаар эзэн холбогдогч нь тодорхойгүй гэрийн мод хийх зориулалтаар бэлтгэсэн 150 ширхэг бургасыг мөн эзэн холбогдогчтой 300 ширхэг бургасыг хураан авч Үнэ тогтоох зөвлөлийн шийдвэрээр 1 ширхэгийг нь 1500 төгрөгөөр худалдан борлуулж, улсын орлого болгохоор шийдвэр гаргуулан, зөрчил гаргасан иргэнд 14 хоногийн хугацаанд байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулж, төлүүлэх нөхөн төлбөрийн хуудас өгч захиргааны арга хэмжээ авч ажиллав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР